МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 09 сарын 29 өдөр Дугаар 04 Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль
тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.2 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан нарт даалгасугай.

1.1.“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дунд хугацааны зорилт, арга хэмжээг байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн тайланд үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Ёс зүйн хороонд ирүүлэх;

1.2.Ёс зүйн дэд хороог бие даасан, хараат бусаар ажиллах боломж, нөхцөлөөр хангаж, гишүүдийн урамшуулал, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх;

1.3.Ёс зүйн эрсдэлийн үнэлгээг нийт албан хаагчдыг хамруулан хийж, үр дүнд үндэслэн зохих арга хэмжээг авч тайлагнах;

1.4.Жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулдаг "Ёс зүйн нөлөөллийн сар"-ын хүрээнд байгууллагын соёл, эерэг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

2.Төрийн албаны ёс зүйн индексийг тодорхойлох аргачлалын төслийг турших судалгаа болон өгөгдөл цуглуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Ёс зүйн хорооны хуралдаанд танилцуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Н.Ганбаатар)-нд үүрэг болгосугай.

ДАРГА Ц.АМАРТӨГС

152601012

وکالت‌نامه دفتر اسناد رسمی

وکیل: آقای ... به شماره ملی ...

وکالت دفتر اسناد رسمی

وکالت دفتر اسناد رسمی دفتر ... به شماره ملی ...

وکالت‌نامه دفتر اسناد رسمی دفتر ... به شماره ملی ... صادر از ... به وکیل: آقای ... به شماره ملی ... صادر از ... به وکالت